



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

2017 оны 09 сарын 07 өдөр

Дугаар 125

Номгон

Хуулийн этгээд байгуулах тухай

Монгол Улсын Боловсролын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2.4, 77.3 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ

нь:

1. Баянхонгор аймгийн Баянхонгор сумын Номгон 1 дүгээр багийн нутаг дэвсгэрт байрлах 75 хүүхдийн суудал бүхий улсын төсвийн санхүүжилттэй Арван дөрөвдүгээр цэцэрлэгийг үүсгэн байгуулсугай.

2. Арван дөрөвдүгээр цэцэрлэгийн үйл ажиллагааны дүрмийг хавсралтаар баталсугай.

3. Цэцэрлэгийн үйл ажиллагааг явуулах тусгай зөвшөөрлийг зохих журмын дагуу олгож, удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг аймгийн Засаг дарга /Г. Батжаргал/-д даалгасугай.

ДАРГА

Ц.ОТГОНБАЯР

0117067

БАЯНХОНГОР СУМЫН АРВАН
ДӨРӨВДҮГЭЭР ЦЭЦЭРЛЭГИЙН ДҮРЭМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1 Баянхонгор аймгийн Баянхонгор сумын Арван дөрөвдүгээр хүүхдийн цэцэрлэг нь /цаашид цэцэрлэг гэнэ/ Монгол Улсын “Боловсролын тухай хууль”, “Бага дунд боловсролын тухай хууль”, бусад хууль тогтоомж, боловсролын асуудал эрхэлсэн болон бусад холбогдох төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан тушаал, шийдвэрийг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллана.

1.2 Цэцэрлэг нь өөрийн онцлогт тохируулан цэцэрлэгийн дүрэм боловсруулан мөрдөж ажиллана.

1.3 Цэцэрлэг нь тухайн байгууллагын үйл ажиллагааг зохицуулсан дотоод журамтай байна.

1.4 Цэцэрлэг нь орон нутгийн боловсролын удирдах байгууллагаас гаргасан мэргэжлийн удирдамж, чиглэлийг баримтална.

1.5 Цэцэрлэг нь байгууллага хөгжүүлэх үзэл баримтлал, хэтийн болон үйл ажиллагааны төлөвлөгөөтэй байна.

1.6 Цэцэрлэг нь ардчилал, ил тод байдал, хамтын удирдлагын зарчимд тулгуурлан үйл ажиллагаагаа зохион байгуулна.

1.7 Цэцэрлэгт эрхлэгч, багш, туслах багш, тогооч, үйлчилгээний бусад ажилчид ажиллана.

1.8 Төрийн болон төрийн бус байгууллага, гадаад орон, олон улсын байгууллага, иргэдтэй гэрээ хэлцэл байгуулан үр дүнтэй хамтран ажиллаж болно.

1.9 Цэцэрлэг нь хуулийн этгээд бөгөөд зохих журмын дагуу хийсэн тэмдэг, албан бичгийн хэвэлмэл хуудас хэрэглэнэ.

1.10 Цэцэрлэг нь өөрийн үйл ажиллагааны талаар эцэг, эх асран хамгаалагчдын мэдээлэл авах эрхийг хангаж ажиллана.

1.11 Цэцэрлэг нь Хүүхдийн эрхийн тухай олон улсын гэрээ, конвенци, үндсэн хууль тогтоомжинд нийцсэн “Хүүхэд хамгаалалын бодлого”-г хэрэгжүүлнэ.

1.12 Цэцэрлэгийн дэргэд цэцэрлэгийн төлөөлөл, эцэг эхийн төлөөлөлөөс бүрдсэн зөвлөлтэй байх бөгөөд ажиллах журмыг тусгайлан мөрдөж ажиллана.

1.13 Цэцэрлэгийн орчинг хүүхдэд эрүүл аюулгүй байх нөхцөл боломжийг бүрдүүлсэн холбогдох стандарт, эрх зүйн баримт бичигт заасны дагуу мөрдөн ажиллах.

1.14 Цэцэрлэг нь харилцан хүлээх эрх, үүргийг тусгайлан гурвалсан гэрээ хүүхдийн эцэг, эх асран хамгаалагчтай хичээлийн жилийн эхний сард багтаан хийж баталгаажуулах, мөрдөн ажиллах.

ХОЁР. ЦЭЦЭРЛЭГИЙН БҮТЭЦ, УДИРДЛАГА

2.1 Цэцэрлэгийн өөрийн удирдлагыг цэцэрлэгийн зөвлөл, мэргэжил арга зүйн удирдлагыг цэцэрлэгийн заах аргын нэгдэл хэрэгжүүлнэ.

2.2 Цэцэрлэг нь эцэг, эхийн санал, хүсэлтэд үндэслэн ажиллах цагийг уян хатан тогтоож, уртасгасан, богиносгосон цагаар ажиллаж болно. Эцэг эх, асран хамгаалагчаас шалтгаалан багш илүү цагаар ажилласан тохиолдолд эцэг, эхээс төлбөр авах асуудлыг цэцэрлэгийн зөвлөлийн шийдвэр, эцэг, эхтэй байгуулсан гэрээний дагуу зохицуулна.

2.3 Цэцэрлэгийн бага бүлгийг дундажаар 20, дунд, ахлах, бэлтгэл бүлгийг дундажаар 25, холимог бүлгийг дундажаар 20 хүүхэдтэйгээр зохион байгуулна.

2.4 Цэцэрлэг нь салбар бүлэгтэй байж болно.

2.5 Хөнгөн хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг цэцэрлэгийн ердийн бүлгийн хүүхдүүдтэй хамт сургаж болно. Нэг бүлэгт хөнгөн хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй 2 хүртэл хүүхэд байж болно.

2.6 Цэцэрлэг нь хамран сургах тойргийн цэцэрлэгт хамрагдаагүй сургуулийн өмнөх насны хүүхдэд хувилбарт сургалт зохион байгуулж болно. Хүүхэд 200 цагийн сургалтад хамрагдсан тохиолдолд тэднийг сургуулийн өмнөх боловсролд хамрагдсанд тооцно.

ГУРАВ. ХҮҮХДИЙГ ХӨГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

3.1 Цэцэрлэгийн хичээлийн жил нь 09 дүгээр сарын 01-нээс дараа оны 06 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл үргэлжилнэ.

3.2 Цэцэрлэгийн шинээр бүртгэх, анги дэвших бүртгэлийг жил бүрийн 08 дугаар сарын 26-28-ны өдрийн хооронд бүртгэнэ.

3.3 Цэцэрлэг нь бага насны хүүхдийг асран хамгаалах, тэдний бие бялдар оюун ухаан, нийгэмшихүйн хөгжлийг хангах үйл ажиллагаа зохион байгуулахын зэрэгцээ эцэг эхэд нь хүүхдээ хөгжүүлж, хүмүүжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

3.4 Цэцэрлэг нь "Сургуулийн өмнөх боловсролын сургалтын цөм хөтөлбөр" Бага насны хүүхдийг хөгжүүлэх үйл ажиллагаа нь тэдний нас, сэтгэхүйн хөгжлийн түвшин, хэрэгцээ сонирхолд нийцсэн байна.

3.5 Цэцэрлэг нь сургуулийн өмнөх боловсролын стандартад нийцүүлэн орон нутгийн болон цэцэрлэгийнхээ онцлогт тохирсон сургалтын хөтөлбөр боловсруулж мөрдөнө.

3.6 Цэцэрлэгийн эрхлэгч нь нэг өдрийн ажлын цагт багтаан багш нарт дараа өдрийн хичээл, үйл ажиллагааг зохион байгуулахад бэлтгэх 1-2 цагийн зохицуулалт хийж өгнө.

ДӨРӨВ. ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХ, ҮҮРЭГ

4.1 Батлагдсан төсөвд багтаан ажилтны орон тоо, норматив, статистик мэдээнд өгөгдсөн хүүхдийн тоог барин ажиллана.

4.2 Монгол Улсын Хөдөлмөрийн хууль, бусад эрх зүйн баримт бичгийг үндэслэн цэцэрлэгийн багш, ажилтныг ажилд авах, ажлаас чөлөөлөх, шагнаж урамшуулах, Төрийн дээд шагналд тодорхойлож болно. Мөн сахилгын шийтгэл, эд материалын дутагдал гаргах, хүүхэдтэй зүй бус харьцах зэрэг хариуцлагын эрхлэгч хүлээлгэн хариуцлага тооцон ажиллана.

4.3 Батлагдсан төсөв хөрөнгийг ашиглан сургалтын техник хэрэгсэл, тоног төхөөрөмж зэрэг эд хөрөнгө худалдан авч хэрэгцээ хангахгүй болсон элэгдэж хуучирсан эд хөрөнгийг зохих журмын дагуу актлана.

4.4 Боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас гаргасан дүрэм журмын дагуу гадаад, дотоодын байгууллага, цэцэрлэг, иргэдтэй гэрээ хэлцэл байгуулан үр ашигтай хамтран ажиллана.

4.5 Батлагдсан цалинг үндэслэн багш, ажилтны цалинг хууль, тогтоомжийн дагуу тогтоон, ур чадвар, зэрэг дэвийн нэмэгдэл олгож, шаардлагатай үед дотоод журамд заасан тэтгэмж олгоно.

4.6 Цэцэрлэг нь ёс суртахуун, эрүүл мэндийн боловсролын анхны мэдэгдэхүүн эзэмшүүлэх чигэлээр нэмэлт сургалт зохион байгуулж болно.

4.7 Хүүхдийн эрүүл мэндийг хамгаалах, тэднийг эрүүлжүүлэх, чийрэгжүүлэх ажлыг эрүүл мэндийн байгууллагын дэмжлэгтэйгээр зохион байгуулна.

4.8 Цэцэрлэгийн хүүхэд нас бие, сэтгэхүйн онцлогт тохирсон хүмүүжил сургалтын чанартай зохион байгуулж явуулах, тэдний авъяас сонирхолыг хөгжүүлэх, ариун цэвэр, аюулгүй ажиллагааны журмыг чанд сахиж ажиллах.

4.9 Цэцэрлэгийн үйл ажиллагаа болон шийдвэр гаргах үйл явцад эцэг, эх гэр бүлийн гишүүдийг татан оролцуулах тэдний ухамсартай байнгын дэмжлэгийг бий болгоход анхаарч эцэг, эх цэцэрлэгийн хамтын ажиллагааг бэхжүүлэх.

4.10 Цэцэрлэг нь хүүхдэд амт чанар илчлэг сайтай олон нэр төрлийн хоолоор үйлчилнэ. Хүүхдийг осол гэмтлээс урьдчилан сэргийлэх тэдний хувийн ариун цэврийг

сахиулах, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх цэцэрлэгийн эрүүл ахуйн дэглэмийг чанд мөрдөх, арга хэмжээ авч ажиллах ба багш ажилчдыг жилд хоёр удаа эрүүл мэндийн үзлэгт хамруулах

4.11 Төрийн захиргааны төв байгууллагаас баталж гаргасан хүүхдийн цэцэрлэгийн багшийн ажлын байрны тодорхойлолтыг үндэслэн цэцэрлэгийн багш, ажилтны ажил үүргийн ажлын чиглэлийг тодорхойлсон гэрээний дагуу ажилд авч ажиллах нөхцөлөөр хангана.

4.12 Цэцэрлэгийн ил тод байдлыг хангах зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэн жил бүр эцэг эхчүүдэд тайлагнана.

ТАВ. ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ, БАГШИЙН ЭРХ ҮҮРЭГ

5.1 Цэцэрлэгийн үйл ажиллагаанд хамрах хууль тогтоомж, эрх зүйн бусад акт шийдвэрийг хэрэгжүүлэн ажиллана.

5.2 Цэцэрлэгийн эрхлэгч нь багш нарыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж, сургалтын үйл ажиллагаа, үр дүнд хяналт тавина.

5.3 Ажилтан нь ямар нэгэн байдлаар хүүхдийн эрхийг зөрчсөн хүчирхийлэл үйлдсэн нь тогтоогдвол шуурхай арга хэмжээ авч хариуцлага тооцох бөгөөд хүүхдийн хүмүүжилд сөрөг нөлөө үзүүлсэн ажилтныг цаашид ажиллуулахгүй байх бодлого баримтлах.

5.4 Цэцэрлэгийн орчин нөхцлийг сайжруулах шаардлагатай засвар үйлчилгээ хийлгэх санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлэхэд санаачлагатай ажиллах.

5.5 Цэцэрлэгийн багш нь багшлах эрхтэй байна.

5.6 Цэцэрлэгийн багш, туслах багш сургуулийн өмнөх боловсролын мэргэжилтэй, цэцэрлэгийн үйл ажиллагаанд мөрдлөг болгох хууль, тогтоомжийн эрх зүйн баримт бичиг, багшийн ёс зүйн дүрмийг үйл ажиллагаандаа мөрдлөгө болгон ажиллах.

5.7 Багшийн хичээл, үйл ажиллагаанд бэлтгэх хугацаанд туслах багш хүүхдүүдтэй хамт байна.

5.8 Цэцэрлэг нь ээлжийн багш ажиллуулж болно.

5.9 Туслах багш нь хүүхдийг хөгжүүлэх үйл ажиллагаа зохион байгуулахад багшид дэмжлэг үзүүлнэ.

5.10 Цэцэрлэгт бага насны хүүхдийг хөгжүүлж, хүмүүжүүлэх чиглэлээр 3 кредит цагаас доошгүй хугацааны сургалтад хамрагдсан туслах багшийг ажиллуулна.

5.11 Цэцэрлэгийн зөвлөл эцэг, эхийн зөвлөл тухайн эцэг, эхийн санаачилга зөвшөөрөлтэйгээр хийгдсэнээс бусад асуудлаар хүүхдийн эцэг, эх асран хамгаалагчаас санхүүгийн болон бусад дэмжлэг авахыг шаардахыг хориглоно.

ЗУРГАА. БУСАД АЖИЛТНЫ ЭРХ ҮҮРЭГ

6.1 Цэцэрлэгийн хэвийн үйл ажиллагааг хангаж ажиллах бусад ажилтнууд нь холбогдох хууль тогтоомж, дүрэм журам, хүүхэд хамгааллын бодлого, цэцэрлэгийн аюулгүй ажиллагааны дүрэм, байгууллагын дотоод журмыг ханган ажиллана.

6.2 Цэцэрлэгийн хэвийн үйл ажиллагааг ханган ажиллахад ажилтнуудын ажиллах нөхцөл боломж, ажлын байрны тодорхойлолт, хөдөлмөрийн гэрээг зохион хууль тогтоомжийн дагуу цэцэрлэгийн эрхлэгч гаргаж батлана.

6.3 Хүүхдэд ээлтэй орчинг бий болгох, цэцэрлэгийн хэвийн үйл ажиллагааг хангахаас гадна багш, эцэг эхтэй найрсаг, нягт уялдаа холбоотой ажиллах.

ДОЛОО. ХҮҮХДИЙН ЭРХ, ҮҮРЭГ

7.1 Хүүхэд нь Хүүхдийн эрхийн тухай конвенци, Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль, Хүүхэд хамгааллын дүрэм журамд заасны дагуу эрхийг эдлэх эрхтэй.

7.2 Хүүхэд эрүүл аюулгүй стандарт шаардлагад нийцсэн орчинд сурч хүмүүжих эрхтэй.

7.3 Хүүхдийн хөгжилд тохирсон сургалтын хүртээмжтэй хэрэглэгдэхүүн, хүүхэд сурч хүмүүжих таатай орчноор хангагдах эрхтэй.

7.4 Хүүхэд эрүүл аюулгүй чанарын шаардлагад нийцсэн хоол хүнсээр хангагдах эрхтэй.

7.5 Хүүхэд цэцэрлэгийн орчинд бие махбодь, сэтгэл санааны дарамт хэл амаар доромжлуулах, ялгаварлан гадуурхагдах, аливаа хэлбэрийн хүчирхийлэлээс хамгаалуулах эрхтэй.

НАЙМ. ЭЦЭГ ЭХИЙН ЭРХ

8.1 Хууль тогтоомж, цэцэрлэгийн үйл ажиллагаанд баримтлах бусад дүрэм, журам заавар, гурвалсан гэрээнд заасан эрхийг эдлэнэ.

8.2 Цэцэрлэгийн материаллаг баазыг бэхжүүлэх сургалт хүмүүжлийн ажилд чанар үр дүнг сайжруулахад дэмжлэг үзүүлэх, цэцэрлэг эцэг эхчүүдийн хамтын ажиллагааг бэхжүүлэх зорилгоор "Эцэг эхийн зөвлөл"-ийг баталж ажиллуулна.

8.3 Цэцэрлэгийн үйл ажиллагаа үйлчилгээний талаар үнэлгээ өгөх, сайжруулахын тулд өөрийн санал бодлоо илэрхийлэх, хяналт тавих эрхтэй.

8.4 Эцэг эхчүүд цэцэрлэгийн удирдлага, ангийн багштай зөвшилцсөний үндсэн дээр хүүхдийг хөгжүүлэх хүүхдийн сурч хүмүүжих таатай орчинг бүрдүүлэх зорилгоор тодорхой зохион байгуулалттай ажил сургалтыг цэцэрлэг дээр өөрийн хүсэл санаачилгаар зохион байгуулах эрхтэй.

8.5 Цэцэрлэгийн багш, ажилтануудын харилцаа, ёс зүйн талаар санал хүсэлт, гомдол гаргах эрхтэй.

ЁС. ЭЦЭГ ЭХИЙН ҮҮРЭГ

9.1 Хууль тогтоомж, цэцэрлэгийн үйл ажиллагаанд мөрдөн ажилладаг дүрэм, журам, заавар, гурвалсан гэрээний заалтыг биелүүлэх үүрэгтэй.

9.2 Хүүхдийн хөгжил сурах үйл ажиллагаанд туслах, мэдлэг, чадвар эзэмшихэд нь дэмжлэг туслалцаа үзүүлэх тэдний сурсан зүйлийг улам бататгах, хөгжүүлэхэд анхаарах үүрэгтэй.

9.3 Цэцэрлэгийн багшийн ажлын нөхцөл байдлыг харгалзан үзэж тэдний ажилд хүдэтгэлтэй хандаж эелдэг харилцааг эрхэмлэх.

9.4 Цэцэрлэгт хүүхэд ээлтэй орчин бүрдүүлэхэд анхаарч цэцэрлэгийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх үүрэгтэй.

9.5 Эцэг, эх нь өөрийн хүүхдийн хувийн онцлог хөгжлийн талаар багшид тус болох мэдээллийг байнга өгч хамтран ажиллах үүрэгтэй.

9.6 Эцэг эх хүүхдийн ариун цэвэр, халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх үүрэгтэй.

АРАВ. САНХҮҮЖИЛТ

10.1 Цэцэрлэгийн үйл ажиллагаанд зориулагдсан төсөв цалингийн сан, хөрөнгийг зохих ёсоор зөв зарцуулна.

10.2 Цэцэрлэгийн санхүүгийн үйл ажиллагаа нь бие даасан байна.

10.3 Цэцэрлэгийн эрхлэгч нь санхүүгийн үйл ажиллагааныхаа дүнг цэцэрлэгийн зөвлөл, хамт олон, эцэг, эхэд нээлттэй ил тод байхаас гадна тайлагнана.

10.4 Цэцэрлэг нь өөрийн үйл ажиллагаанд зориулан дотоод гадаадын хуулийн этгээд иргэн эцэг, эх асран хамгаалагч олон усын байгууллага төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх, хамтран ажиллах хэлбэрээр тодорхой хэмжээний хандив тусламж, санхүүжилт авч болно.

10.5 Энэхүү хандив, тусламж аливаа хэлбэрийн санхүүжилт нь хүүхдийн сурч хүмүүжих, эрүүл аюулгүй таатай орчинг бүрдүүлэхэд чиглэгдсэн байна.